АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН МАЯГТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☐ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:	Төрийн албаны тухай хууль
Дагаж мөрдөх огноо:	2021.09.21
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:	2024.10.09

Байгууллагын нэр:	Нэгжийн нэр:
Засгийн газрын хэрэг эрхлэх газар	ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ГАЗАР
Албан тушаалын нэр:	Албан тушаалын ангилал, зэрэглэл, төрөл:
Хууль, эрх зүйн газрын дарга	Тэргүүн түшмэл, , АА-2, Удирдах
Ажлын цаг:	Ажлын байрны албан ёсны байршил:
8	Монгол улс Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг
Хөдөлмөрийн нөхцөл:	Онцгой нөхцөл:
Хэвийн	

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Хууль тогтоомжийн болон Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах, хуулиудын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах ажлын хүрээнд шийдвэрийн төсөл боловсруулах, танхимын хуралдаанаас гарах шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг хянах, агуулгыг найруулах, эдгээр асуудлаар удирдлагыг зөвлөгөө, арга зүй, мэдээлэл, лавлагаагаар хангах чиг үүргийн хүрээнд нэгжийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, гүйцэтгэл, үр дүнг удирдлагын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төслийг Үндсэн хууль, холбогдох бусад тогтоомжид нийцүүлэн боловсруулах болон хууль тогтоомжийн төслийг хянах асуудлыг зохион байгуулах;
2. Засгийн газрын шийдвэрийг хууль тогтоомжид нийцүүлэн гаргах, хэрэгжүүлэхэд хууль, эрх зүйн зөвлөгөө өгөх, хууль тогтоомжийн төсөл боловсруулах, дүн шинжилгээ хийх, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүдэд хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн талаар лавлагаа өгөх, Засгийн газрын нууцын архив болон бусад шаардлагатай мэдээллээр хангах, бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх;
3. Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, ЗГХЭГ-ын удирдлагыг шаардлагатай хууль, эрх зүйн зөвлөгөө, үйлчилгээгээр цаг тухайд нь хангах;
4. Нэгжийн дотоод үйл ажиллагааг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах;
5. Хууль тогтоомжид заасан нийтлэг үүргийг хэрэгжүүлэх.

Зорилт	**Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг**	**Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт**	**Хариуцлага, оролцооны хэлбэр** Туслах - **Т**, Хариуцан гүйцэтгэх - **Г** Хянах – **Х** Шийдвэрлэх – **Ш**
1 дүгээр зорилтын хүрээнд	Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх асуудлыг хүлээн авч танилцах, тухайн асуудал хууль тогтоомж, Засгийн газрын бодлогод нийцэж байгаа эсэхийг хянах, эдийн засгийн үндэслэл, тооцоо судалгаа болон салбарын онцлогийг үндэслэн зөвлөгөө өгөх, зөвлөгөөг яам, агентлаг, холбогдох байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр төсөлд тусган боловсруулах, уг асуудлаар газрын холбогдох албан хаагчид чиглэл өгөх;	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөл холбогдох хууль тогтоомжид нийцсэн, боловсруулалтын шаардлага хангасан, хууль зүйн үндэслэлтэй, гаргаж байгаа шийдвэр нь цаг үеэ олсон байх.	Г, Х
	Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэх асуудлаар ЗГХЭГ-ын санал бэлтгэх, Ерөнхий	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөл холбогдох хууль	Г, Х

	сайд болон ЗГХЭГ-ын дарга, Тэргүүн дэд даргад танилцуулах, хууль тогтоомжид нийцээгүй, боловсруулалтын шаардлага хангаагүй асуудлыг буцаах санал бэлтгэх, уг асуудлаар газрын холбогдох албан хаагчид чиглэл өгөх;	тогтоомжид нийцсэн, боловсруулалтын шаардлага хангасан, хууль зүйн үндэслэлтэй, гаргаж байгаа шийдвэр нь цаг үеэ олсон байх.	
	Яамдаас санаачлан боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ирүүлсэн хууль тогтоомжийн төслийг хянан боловсруулах, төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, хуралдаанаас гарсан саналыг төсөлд тусган эцэслэн боловсруулах, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлтгэх;	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөл холбогдох хууль тогтоомжид нийцсэн, боловсруулалтын шаардлага хангасан, хууль зүйн үндэслэлтэй, гаргаж байгаа шийдвэр нь цаг үеэ олсон байх.	Г, Х
	Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүний санаачлан боловсруулсан хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлтийн төслийг боловсруулах, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, санал, дүгнэлтийг эцэслэн боловсруулж албажуулах, хууль санаачлагчид хүргүүлэх, уг асуудлаар газрын холбогдох албан хаагчид чиглэл өгөх;	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөл холбогдох хууль тогтоомжид нийцсэн, боловсруулалтын шаардлага хангасан, хууль зүйн үндэслэлтэй, гаргаж байгаа шийдвэр нь цаг үеэ олсон байх.	Г, Х
	Засгийн газрын хуралдаанд оролцож, тэмдэглэл хөтлөх, хураангуй тэмдэглэлийг хянах;	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөл холбогдох хууль тогтоомжид нийцсэн, боловсруулалтын шаардлага хангасан, хууль зүйн	Г, Х

		үндэслэлтэй, гаргаж байгаа шийдвэр нь цаг үеэ олсон байх.	
	Холбогдох яам, агентлагийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр Ерөнхий сайд, ЗГХЭГ-ын удирдлагыг хангах.	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөл холбогдох хууль тогтоомжид нийцсэн, боловсруулалтын шаардлага хангасан, хууль зүйн үндэслэлтэй, гаргаж байгаа шийдвэр нь цаг үеэ олсон байх.	Х, Г
2 дүгээр зорилтын хүрээнд	ЗГХЭГ-ын удирдлагаас өгсөн үүргийн дагуу хууль тогтоомжийн төслийн үзэл баримтлалыг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулах;	ЗГХЭГ-аас өгөх санал, дүгнэлт нь хууль зүйн үндэслэлтэй, албан хэрэг хөтлөлтийн стандарт шаардлагыг хангасан байх.	Г, Х
	Хууль тогтоомжийн төсөлтэй холбоотой материал бүрдүүлэх, судалгааны ажил хийх, хуулийн төсөл боловсруулах, энэ талаар удирдлагыг мэргэшил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл, үйлчилгээгээр хангах;	ЗГХЭГ-аас өгөх санал, дүгнэлт нь хууль зүйн үндэслэлтэй, албан хэрэг хөтлөлтийн стандарт шаардлагыг хангасан байх.	Г, Х
	ЗГХЭГ-ын удирдлагаас өгсөн үүргийн дагуу хууль тогтоомжид нийцүүлэн Засгийн газрын шийдвэр /тогтоол, захирамж/-ийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах;	ЗГХЭГ-аас өгөх санал, дүгнэлт нь хууль зүйн үндэслэлтэй, албан хэрэг хөтлөлтийн стандарт шаардлагыг хангасан байх.	Г, Х
	Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн төсөлд яам, бусад байгууллагаас санал, дүгнэлт авч, дүн шинжилгээ хийх, саналыг нэгтгэж төсөлд тусгуулах;	Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндсэн хуулийн болон холбогдох бусад төрийн байгууллагатай харилцах асуудлыг хуулийн хүрээнд шуурхай, зөв зохион байгуулсан байх.	Х

	ЗГХЭГ-ын даргын эрхэлсэн асуудлын хүрээний болон түүний ахалсан ажлын хэсгийн хүрээнд Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах;	Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндсэн хуулийн болон холбогдох бусад төрийн байгууллагатай харилцах асуудлыг хуулийн хүрээнд шуурхай, зөв зохион байгуулсан байх.	Х, Г
	Хариуцсан асуудал, удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндсэн хуулийн болон холбогдох бусад төрийн байгууллага, гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагатай харилцах, холбогдох асуудлаар санал, шаардлагатай мэдээлэл, лавлагаа, танилцуулга боловсруулах арга хэмжээ авах.	Улсын Их Хурлын Тамгын газар, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндсэн хуулийн болон холбогдох бусад төрийн байгууллагатай харилцах асуудлыг хуулийн хүрээнд шуурхай, зөв зохион байгуулсан байх.	Г, Х
	ЗГХЭГ-ын удирдлагын эрх олгосноор гадаадын иргэн, харьяатын асуудал болон нууцын албан хэрэг хөтлөлт, Засгийн газрын нууцын архивын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар байгууллага, албан тушаалтантай харилцах, удирдлагыг шаардлагатай баримт, мэдээллээр хангаж ажиллах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна	Г, Х
	Удирдлагын шийдвэрийн дагуу Засгийн газар, Хэрэг эрхлэх газрыг шүүх, прокурорт төлөөлөх.	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна	Г, Х
3 дүгээр зорилтын хүрээнд	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн чиг үүрэгт	Зөвлөгөө, үйлчилгээнь судалгаанд тулгуурласан, эрх зүйн үндэслэлтэй, цаг үеэ олсон,	Г, Х

	хамаарах асуудлыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх;	тооцоо судалгаатай, шуурхай байх.	
	ЗГХЭГ-ын үйл ажиллагааны стратеги, тэргүүлэх чиглэлийг үндэс болгон өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах ажлыг хэрэгжүүлэх;	Зөвлөгөө, үйлчилгээнь судалгаанд тулгуурласан, эрх зүйн үндэслэлтэй, цаг үеэ олсон, тооцоо судалгаатай, шуурхай байх.	Х, Ш
	ЗГХЭГ-ын жил бүрийн төлөвлөгөөнд тусгагдсан, өөрийн чиг үүрэгт хамаарах асуудлыг хэрэгжүүлэх;	Зөвлөгөө, үйлчилгээнь судалгаанд тулгуурласан, эрх зүйн үндэслэлтэй, цаг үеэ олсон, тооцоо судалгаатай, шуурхай байх.	Х, Ш
	Засгийн газар, Ерөнхий сайдын үйл ажиллагаа, тэдгээрийн гаргасан шийдвэртэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд итгэмжлэгдсэн төлөөлөгч оролцуулах асуудлыг зохион байгуулах;	Зөвлөгөө, үйлчилгээнь судалгаанд тулгуурласан, эрх зүйн үндэслэлтэй, цаг үеэ олсон, тооцоо судалгаатай, шуурхай байх.	Х
	Удирдлагаас өгсөн үүргийн дагуу ЗГХЭГ-ын дарга, төсвийн шууд захирагчийн тушаалын төслийг хууль тогтоомжид нийцүүлэн хянах;	Зөвлөгөө, үйлчилгээнь судалгаанд тулгуурласан, эрх зүйн үндэслэлтэй, цаг үеэ олсон, тооцоо судалгаатай, шуурхай байх.	Х
	Иргэдээс Ерөнхий сайд болон ЗГХЭГ-ын удирдлагад хандсан өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэхтэй холбоотой зөвлөгөө, үйлчилгээгээр удирдлага, холбогдох газар, хэлтэс, албан хаагчдыг хангах.	Зөвлөгөө, үйлчилгээнь судалгаанд тулгуурласан, эрх зүйн үндэслэлтэй, цаг үеэ олсон, тооцоо судалгаатай, шуурхай байх.	Х
4 дүгээр зорилтын хүрээнд	Газрын үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж ЗГХЭГ-ын Тэргүүн дэд даргаар батлуулан хэрэгжүүлэх;	Газрын үйл ажиллагаа шуурхай, мэргэшсэн, үр нөлөө тодорхой байх, газрын дотоод үйл ажиллагаа хэвийн явагдсан байх.	Г
	Нэгжийн албан хаагчдын жилийн гүйцэтгэлийн	Газрын үйл ажиллагаа шуурхай,	Х, Ш

	төлөвлөгөөг баталж, хагас, бүтэн жилээр тайланг гаргуулан дүгнэж, үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг үнэлэх;	мэргэшсэн, үр нөлөө тодорхой байх, газрын дотоод үйл ажиллагаа хэвийн явагдсан байх.	
	Хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, ЗГХЭГ-ын даргаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх;	Газрын үйл ажиллагаа шуурхай, мэргэшсэн, үр нөлөө тодорхой байх, газрын дотоод үйл ажиллагаа хэвийн явагдсан байх.	Х
5 дүгээр зорилтын хүрээнд	ЗГХЭГ-ын удирдлагаас өгсөн хуульд нийцсэн үүрэг даалгаврыг биелүүлэх, Ерөнхий сайдын захирамж, ЗГХЭГ-ын даргын тушаалаар байгуулсан холбогдох Ажлын хэсэгт орж ажиллах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна	Г
	Засгийн газар, Ерөнхий сайд, ЗГХЭГ-т төрийн захиргааны бүх шатны байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага, иргэдээс ирсэн санал хүсэлтийг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхтэй холбоотой зөвлөгөө, үйлчилгээгээр удирдлагыг хангах, асуудлыг судалж хариу төлөвлөх, холбогдох байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх асуудлыг судалж удирдлагад танилцуулж зохих журмын дагуу шийдвэрлэх;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна	Г
	Эрхэлсэн ажил үүргийн хүрээнд шийдвэрлэсэн асуудлын хяналтын картыг тухай бүрт нь хаах, үйл ажиллагааны явцад гарсан баримт бичгийг ангилан хэрэг	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна	Г

	бүрдүүлж, Засгийн газрын архивт зохих журмын дагуу шилжүүлсэн байх.		
	Тухайн албан тушаалын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан холбогдох нууцын баталгааг авахад шаардагдах материалыг гаргаж өгөх.	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байна	Г

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА		
Боловсрол	Бакалавр болон магистрын боловсролын зэрэгтэй	
Мэргэжил	Эрх зүй /042/	
Мэргэшил	Тэргүүн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад хамрагдаж төгссөн байх.	
Туршлага	Төрийн албанд 16-аас доошгүй жил, үүнээс эрхэлсэн түшмэлийн албан тушаалд 8-аас доошгүй жил ажилласан байх.	
Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- мэдээлэлд тулгуурлан бүтэц чиг үүргийн шинжилгээ хийх, системийн шинжилгээ хийх, хяналт шинжилгээ үнэлгээ хийх; - хууль тогтоомжийн төслийг харьцуулан судалж, дүн шинжилгээ хийх, зөвлөмж боловсруулах; - мэдээлэлд тулгуурлан чиг үүргийн шинжилгээ хийх; - ажлын албаны үйл ажиллагаанд хяналт шинжилгээ үнэлгээ хийх; - бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмж боловсруулах; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- аливаа асуудлыг албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх; - хууль тогтоомжийн төслийн заалтын давхардал, зөрчлийг арилгах, уялдаа холбоог хангах арга замыг хууль тогтоомжийн төсөлд тусгах; - хянасан хууль тогтоомжийн төслийн талаар хариуцлага хүлээх; - Бусад.
	Бусад	- хүний эрхийн стандартуудыг хэрэгжүүлэх; - албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг, хуулийн төсөл боловсруулах; - хууль зүйн техникийн болон практик ур чадвар эзэмшсэн байх;

		- оролцогч талуудын олон талт байдлыг зохицуулах; - удирдлагын болон нэгжийн түвшинд багаар хамтарч ажиллах; - англи хэл эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - компьютерын хэрэглээний программ, мэдээлэл харилцааны технологийг ашиглах чадвартай байх; - мэдээллийг шуурхай солилцох соёл төлөвшүүлэх; - худалдан авах ажиллагааны сургалтад хамрагдаж А3 гэрчилгээ авсан байх; - төрийн нууцтай танилцах эрх олгохтой холбоотойгоор аюулгүй байдлын шалгалт явуулахыг бичгээр зөвшөөрч, эрх бүхий байгууллагын аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж, тэнцсэн байх; - кирилл болон үндэсний бичгээр унших, бичих чадвартай байх.

IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ	
Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр: • Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга	
Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо: Засгийн газрын ахлах референт (2) Засгийн газрын референт (4) - Ахлах шинжээч (2) Шинжээч (3)	**Бусад харилцах субъект** УИХ-ын Тамгын газар, УИХ-д ажлаа тайлагнадаг байгууллагууд, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Үндсэн хуулийн цэц, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Төрийн албаны зөвлөл, яам, агентлаг, нутгийн захиргааны болон бусад төрийн байгууллагын холбогдох албан тушаалтан, Шүүх, прокурорын байгууллагууд. Иргэн, хуулийн этгээдийн холбогдох албан тушаалтан.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ	
<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон</u>

	байгууллагын шийдвэр:
Албан тушаал: Ажилтан (ТЗУГ) …… Уранбилэг, Номин (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2024 оны 10 дугаар сарын 29 -ны өдөр	Байгууллагын нэр: Төрийн албаны зөвлөл Шийдвэрийн огноо: 2024.10.09 Дугаар: 421, 422, 423, 430
Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:	
Байгууллагын нэр: Засгийн газрын хэрэг эрхлэх газар Шийдвэрийн огноо: 2024.10.29 Дугаар: 272, 273, 274 (тамга/тэмдэг) ……..... ..... (Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр) 2024 оны 10 дугаар сарын 29 -ны өдөр	